

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам



1. Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах үйл ажиллагаанд дараах зарчим баримтална.

Хүүхдийн сурч боловсрох, хөгжих эрхийг хүндэтгэх

Хүүхдийн онцлог, хэрэгцээнд нийцсэн чанартай боловсрол эзэмшүүлэх

Хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэх, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлж бусадтай харилцах, хамтран ажиллах, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох оролцоог дэмжих

Аливааг ялгаварлан гадуурхалтаас ангид байх



Сургууль нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 14.3.1 дэх заалтанд заасны дагуу хамран сургах тойрогт хамаарах хүүхдийг сургуульд бүрэн хамруулах ажлыг хариуцна.


Сургууль нь нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын хамтран баталсан зааврын дагуу сум, хорооны “Сургуульд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-тэй хамтран ажиллана.

Сургууль нь хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Сургууль нь хүүхдэд бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэжээг эцэг эх, холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.

Хүүхдийг сургууль, анги танхим, хонгил, ариун цэврийн өрөөнд саадгүй нэвтрэх, аюулгүй зорчих боломжыг бүрдүүлнэ.





Хүүхдийн онцлог
хэрэгцээнд нь тохирох
ном, сурах бичиг, гарын
авлага, материал, тусгай
хэрэглээний сургалтын
тоног төхөөрөмж,
хэрэгслээр хангах

Багш, ажилтанд хүүхдийн
онцлог хэрэгцээнд
нийцсэн заах арга зүй,
арга барил эзэмшүүлэх

Дэмжлэгийн баг

Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах, сургуулийн орчинд дасан зохицох, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшихэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий “Дэмжлэгийн баг”-ийг сургуулийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна.

Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах, сургуулийн орчинд дасан зохицох, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшихэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий “Дэмжлэгийн баг”-ийг сургуулийн захирлын тушаалаар байгуулж ажиллуулна.

Сургууль нь хүүхдийг сургахад Бага, дунд боловсролын тухай хуулийн 13,4-т заасны дагуу ерөнхий боловсролын тусгай сургуулиас мэргэжил, арга зүйн туслалцаа авч хамтран ажиллана.

Сургууль нь хүүхдийн боловсролын ялгаатай хэрэгцээг тодорхойлох, дасан зохицоход дэмжлэг үзүүлж, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, засан сайжруулах, зөвлөгөө өгөх, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Энэхүү журмын 4.1-д заасан үйл ажиллагааны хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.



4.2.1. Хүүхдийн хувийн хэрэгтэй танилцах, эцэг эх асран хамгаалагчтай ганцаарчлан уулзах, хичээлийн болон хичээлийн бус цагаар ажиглалт хийх замаар тухайн хүүхдийн ерөнхий хөгжил, тусгай хэрэгцээг тодорхойлох



4.2.2. Хүүхдийг сургуульд элсэхээс өмнө сургуулийн орчинтой танилцуулах, анги даасан багштай уулзалт хийх, сургуульд сурах хүсэл сонирхол бий болгох, хүүхдэд тохиолдож буй бэрхшээлийг хамтдаа шийдэж урамшуулах, идэвхжүүлэх, хүүхдээс хүүхдэд, үе тэнгийн туслагч хөдөлгөөн өрнүүлэх зэргээр шинэ орчин нөхцөлд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх



4.2.3. Хэл засал, хөдөлгөөн засал, өөртөө үйлчлэх, брайль үсэг, дохионы хэл болон харилцааны бусад арга хэлбэрийг хэрэглэх, орон зай, чиг баримжааны чадвар олгох нэмэлт сургалт зохион байгуулах

4.2.4. Хүүхэд, түүний гэр бүлд эрүүл, мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээнд хэрхэн хамрагдах, хүүхдийн хэл яриа, хөдөлгөөнийг засан сайжруулах, өөртөө үйлчлэх дадалд сургах, хүүхдийн харилцах чадварыг хөгжүүлэх, сэтгэл хөдлөлөө хянах, эерэг зан үйл, хандлагыг төлөвшүүлэх, мэргэжлээ сонгоход нь туслалцаа үзүүлэх арга зүйн зөвлөгөө өгөх



4.2.5. Сургуулийн хамт олон, эцэг эх, асран хамгаалагч, орон нутгийн иргэдэд хүүхдийн хөгжлийн болон сурах онцлогийн талаар мэдээлэл түгээж, нийгмийн эерэг хандлагыг бий болгох нөлөөллийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

4.3. Энэхүү журмын 4.2.4-д заасан нэмэлт сургалтын үйл ажиллагааг сургалтын тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгсэлтэй танхимд хичээлийн бус цагаар зохион байгуулна.

Хүүхдийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан суралцагчийн үнэлгээний дагуу журмын дагуу үнэлж дүгнэнэ.



Анги дэвших болон сургууль төгсөх шалгалтыг тэдний онцлог хэрэгцээ, шаардлагыг хангасан орчин, нөхцөлд авна.